

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.020.50

Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл. Өөрийн зарласан мэдүүлэг (Байгаль орчны эко-тэмдэг хэрэглэх II дахь загвар) Environmantal labels and declarations- Self-declared environmental claims (Type II environmental labelling)	MNS ISO 14021 : 2001
--	-----------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 09 дүгээр сарын 27 өдрийн 49 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт 2001 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандарт нь зөвлөмжийн шинжтэй байна.

1 Хамрах хүрээ

Олон улсын энэ стандартад тодорхойлсон шаардлагын дагуу аж ахуйн нэгж, байгууллагаас бүтээгдэхүүнтэй холбогдуулан байгаль орчны талаар өөрийн зарласан(тунхагласан) мэдүүлэгт график, эко-тэмдэг, мэдэгдлийг оролцуулан гаргаж болно. Ингэснээр цаашдаа энэ мэдүүлэгт нийтлэг нэр томъёог сонгон тодорхойлж хэрэглэнэ. Тэдгээрийг хэрхэн яаж тодорхойлж хэрэглэхийг зааж өгнө.Түүнчлэн олон улсын энэ стандартад байгаль орчны өөрийн зарласан мэдүүлэгийн болоод үнэлэлтийн ерөнхий үнэлгээ, шалгаж нотлох арга зүйг тодорхойлохдоо шалгаж нотлох, онцлогийг тусгана. Олон улсын энэ стандарт нь албан ёсны мөрдлөг болгож буй орчны мэдээлэл, мэдүүлэг, эко-тэмдэг хэрэглэх, эсхүл хууль тогтоомжийн бусад шаардлагыг ямар нэг хэлбэрээр өөрчилж, солих явдалд хамаарахгүй.

2 Норматив ишлэл

Олон улсын энэхүү стандартын зүйлд зааснаар дараахь норматив баримт бичигт иш татах зүйлийн заалтуудыг сэдэвчлэн багтааж оруулна. Дараагийн нэмэлт өөрчлөлт, эсхүл дахин хянах тэдгээрийн хэвлэлтэд хамаарах иш татах хугацааг хамааруулахгүй. Гэхдээ талуудын тохиролцоонд тулгуурлан олон улсын энэхүү стандартаар дор заасан норматив баримт бичгийн хамгийн сүүлчийнх нь байхыг судлагааны боломжоор тогтоож, дэмжинэ. Ишлэл хэрэглэхдээ хугацаа заагаагүй байвал норматив баримт бичгийн хамгийн сүүлчийн хэвлэлийг ашиглана. Тэр нь Олон улсын стандартчиллын байгууллага болон Олон улсын цахилгаан техникийн комиссын жинхэнэ гишүүн орнуудад хүчинтэй.

- MNS ISO 7000, Төхөөрөмжид график тэмдэг хэрэглэх -индекс ба хураангуй тайлбар товъёг,
- ISO 14020 : 1998, Хүрээлэн буй орчны эко-тэмдэг ба тэмдэглэл-Ерөнхий зарчим,

3 Нэр томъёо ба тодорхойлолт

3.1 Ерөнхий нэр томъёо

3.1.1 Дагавар бүтээгдэхүүн

зарим нэгж үйл ажиллагаанаас хоёр буюу түүнээс дээш бүтээгдэхүүнийг боловсруулах.

[ISO 14041 : 1998]

3.1.2

Байгаль орчны асуудал

Байгаль орчинд нөлөөлж болохуйц, тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг

3.1.3

Байгаль орчны мэдүүлэг

Тайлбартай мэдэгдэл, эко-тэмдэг, график, бүтээгдэхүүн буюу сав боодол буюу бүрэлдэхүүн хэсэг нь байгаль орчны асуудлыг зааж тусгана.

Тайлбар: Байгаль (буюу хүрээлэн буй) орчны мэдүүлэгийг бүтээгдэхүүнд, эсхүл түүний сав боодлын хаяг шошго дээр, эсхүл бүтээгдэхүүний тухай ном, техник ашиглалтын эмхэтгэл, нийтийн хэвлэлийн хэрэгсэл, телевизийн маркетинг, аль болох тоогоор, цахим зөөгчийг ашиглан сүлжээгээр дамжуулан гүйцэтгэнэ.

3.1.4.

Байгаль орчны мэдүүлэгийн нотолгоо шалгалт

Найдвартай баримтын баталгаатай журам болон урьдчилан тодорхойлсон шалгуур ашиглаж, байгаль орчны мэдүүлэгийг хүчин төгөлдөр болгон баталгаажуулах.

3.1.5

Байгаль орчинд нөлөөлөх байдал

Тухайн байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс шалтгаалж орчинд үзүүлэх эерэг, сөрөг, бүхэлдээ эсвэл хэсэгчилсэн аливаа өөрчлөлт

3.1.6

Тайлбартай мэдэгдэл

Аливаа тайлбар шаарддаг, эсвэл байгаль орчны мэдүүлэгээр бүтээгдэхүүнийг хэрэглэгч, худалдан авагч, жинхэнэ худалдан авагчийн өмч гэж ойлголт өгч болно.

3.1.7

функционал (үүрэг ажиллагааны) нэгж

“амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээний судалгааны үед лавлагааны нэгж болгон ашиглахад зориулсан бүтээгдэхүүний тогтолцооны гүйцэтгэлийн тоон илэрхийлэл,
[ISO 14040 : 1997]

3.1.8

“Амьдрал”-ын мөчлөг

Түүхий эд, материал олж авах, боловсруулахаас эхлэн байгалийн нөөцийн үйлдвэрлэл, эцсийн хаягдал хүртлэх үеийн бүтээгдэхүүний тогтолцооны дараалсан буюу дамжлага дундын үе шат

3.1.9

Материал таних явц

Бүтээгдэхүүний болон сав боодлын бүтэц найрлага буюу бүрэлдэхүүн хэсгийг тогтооход ашигласан үг, тоо эсхүл тэмдэг

Тайлбар 1. Материалын таних тэмдэг бол байгаль орчны мэдүүлэгийг шийдвэрлэсэн гэж үзэхгүй.

Тайлбар 2. Олон улс, үндэсний стандарт, үйлдвэрлэлийн нийтэд зориулсан хэвлэлд жишээ болгож, материал таних тэмдгийн талаархи лавлагаа[4]-г заан өгч болно.

3.1.10.

Сав баглаа боодол

Бүтээгдэхүүний маркетинг, тээвэрлэлт, хадгалалт, ашиглаж хэрэглэх явцад агуулах, хамгаалахад ашиглах материал

3.1.11.

Бүтээгдэхүүн

Ямарваа нэгэн бараа ба үйлчилгээ

3.1.12

Байгаль орчны хязгаарлагдмал мэдүүлэг

Байгаль орчны мэдүүлэг нь уг мэдүүлэг хязгаарлагдмал болохыг илэрхийлж, тайлбартай мэдэгдэл дагалдуулж байна.

3.1.13

Өөрийн зарласан байгаль орчны мэдүүлэг

Байгаль орчны мэдүүлэг нь гурав дахь талын баталгаажуулалтаас хамааралгүйгээр үйлдвэрлэгч, импортлогч, хуваарилагч, бусад харилцагчийн талд ашигтай байдал гаргасан эрмэлзэл

3.1.14

Өргөжүүлэлтийн байдал

Бүтээгдэхүүний шинж чанар нь түүний угсрагдах эд анги, салангид бүрэлдэхүүн хэсгийг сайжруулах, эсвэл бүхэлд нь орлуулахгүйгээр солих ажиллагаа.

3.1.15

Хаягдал

Хогийн бүх үүсгүүр буюу эзэмшигчийн зүгээс цаашид ашиглахгүй байгаль орчинд хаях аливаа юмс.

3.2 Өөрийн зарласан мэдүүлэгтээ нийтлэг нэр томъёог сонгож ашиглах нь

Дор жагсаасан нэр томъёоноос байгаль орчны мэдүүлэг гаргах хам сэдэвт ашиглах шаардлагыг энэ стандартын 7-р зүйлд зааж өгсөн.

Исэлдэх	7.2.1
Доройтох(хомсдох)	7.3.1
Хэсэгчилсэн зохион байгуулалт	7.4.1
Бүтээгдэхүүний “амьдрал”-ын	

мөчлөг(үе)-ийг уртасгах	7.5.1
Нөхөн сэргээгдэх эрчим хүч	7.6.1
Дахин боловсруулж ашиглах	7.6.1
Дахин боловсруулагдах чадамж	7.8.1.1 а)
Хэрэглэхээс өмнөх материал	7.8.1.1 а) 1)
Хэрэглэсний дараахь материал хэмнэлт	7.8. 1.1 а) 2)
Дахин боловсруулж ашигласан материал	7.8.1.1 б)
Нөхөн сэргээсэн (дахин мэдүүлэх) материал	7.8.1.1 с)
Эрчим хүчний хэмнэлт	7.9.1.
Нөөцийн ашиглалтын хэмнэлт	7.10.1.
Усны хэмнэлт	7.11.1.
Дахин ашиглалт	7.12.1.
Дахин ашиглах ба сэргээх	7.12.1.
Хаягдал бууруулалт(багасгах)	7.13.1.

4 Өөрийн зарласан (тунхагласан) байгаль орчны мэдүүлэгийн зорилго

Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл бол хэд хэдэн зорилготой. Бүтээгдэхүүнтэй холбоо бүхий байгаль орчны асуудлаар төөрөгдөлгүй, зөв мэдээлэл, харилцаа холбоогоор батлан нотолж байгаа тэдгээр бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг ханган хөгжүүлэх явдал бол зах зээлийн удирдлагын хувьд байгаль орчны байнгын сайжруулалтын чадавхийг цаашид урамшуулах, орчны асуудлаарх учир шалтгааныг бага ч гэсэн онцлон авч үзнэ.

Олон улсын энэ стандартын зорилго нь өөрийн зарласан(тунхагласан) байгаль орчны мэдүүлэгийг ашиглан зохицуулахад оршино. Энэ талын ашигтай байдлыг урьдчилан харах боломж бүрдэнэ:

- a) Байгаль орчны мэдүүлэг нь нарийн зөв, нотолж батлагдах, төөрөгдүүлэхээргүй байна,
- b) Бүтээгдэхүүн, үйл явц, үйлдвэрлэл дэх байгаль орчны хамгаалалтыг сайжруулан хөхүүлэн урамшуулж дэмжих, зах зээлийн нөлөө, чадавхийг нэмэгдүүлэх,
- c) Үндэслэлгүй мэдүүлэгийг эрс багасгах буюу түүнээс урьдчилан сэргийлэх,
- d) Зах зээлд гарах элдэв будлианыг багасгах,
- e) Олон улсын худалдааг хөнгөвчлөх, болон
- f) Худалдан авагчдад ая таатай нөхцөл бүрдүүлж, худалдан авах чадвар ба бүтээгдэхүүн хэрэглэгчдэд илүү их мэдээллээр хангаж сонголтыг нь нэмэгдүүлэхэд чиглэнэ.

5 Өөрийн зарласан байгаль орчны бүх мэдүүлэгт тавих шаардлага

5.1 Нийтлэг зүйл

Энэ стандартын 7-р зүйлд буюу байгаль орчны бусад мэдүүлэгт иш татан хэрэглэхээр сонгосны нэг уу, эсвэл мэдүүлэгчийн гаргасан нь 5-р зүйлд заасан шаардлагыг мөрдөнө.

5.2 ISO 14020 тоот стандарттай уялдаа холбоо

Олон улсын энэхүү стандартад нэмэлт болох зарчмыг MNS ISO 14020 тоот стандартад зааснаар мөрдөнө. Энд хамаарахгүй зарим онцлог шаардлагыг дараахь байдлаар зохицуулж болно.

5.3. Тодорхой бус буюу онцгойлох зүйлгүй мэдүүлэг

Байгаль орчинд нөлөөлөлд ийм мэдүүлэгийг хамруулан тодорхой бүтээгдэхүүнд ашиглахгүй байвал зохино. Юуны өмнө, байгаль орчны холбогдолтой дараахь мэдүүлэгт ашиглахгүй. Ийм мэдүүлэг нь: “Экологийн аюулгүй байдал”, “Байгаль орчинтойгоо нөхөрлөө”, “Хог хаягдалгүй байлгая”, “Ногоон зүлэгийг хайрлая”, “Байгаль-бидний анд”, “Озоны найзууд” зэрэг болно.

Тайлбар: Энд дурдсан ерөнхий уриа маягийн нэрийн жагсаалт нь бүгдийг хамраагүй.

5.4. “...гүй тухай мэдүүлэг

Орчинд сөрөг нөлөөлөл бүхий бодисын агуулга, химийн найрлагын холбогдолтой асуудлаар хязгаарлалт, буюу хэм хэмжээг “... гүй”, эсхүл өдий төдий хувь(%)-ийн хэмээн байгаль орчны мэдүүлэгтээ зарлан мэдээлнэ.

Тайлбар: 5.7-ын к), 5.8-ын р) –д заасан шаардлагыг анхаарах нь зүйтэй.

5.5. Байгаль орчны тэнцвэртэй байдлын тухай мэдүүлэг

Байгаль орчны тэнцвэртэй байдалд оруулах тухай ойлголт бол нэлээд төвөгтэй бөгөөд олон жилийн судлагаагаар тайлах боломтой. Энэ цаг хугацаанд тэнцвэртэй байдлын хэмжилтийн аргууд нь хаана байх шаардлагатайг тодорхойлохгүй буюу хэрхэн яаж дуусгавар болгохыг батлахгүй. Юуны өмнө, байгаль орчны тэнцвэртэй байдалд хүрэх талаар мэдүүлэг гаргахгүй.

5.6 Тайлбартай мэдэгдлийг хэрэглэх

Өөрийн зарласан байгаль орчны мэдүүлэг гаргах үед тайлбартай мэдэгдэлтэй хамт уг мэдүүлэг нь дагалдвал үр дүнгийн талаар үл ойлголцолд хүрнэ. Хэрэв хүчин төгөлдөр байхаар, хязгаарлалттай биш байдалтай урьдчилан харахуйц боломж бүхий бүх нөхцөлд байгаль орчны мэдүүлэгийг зөвхөн тайлбартайгаар мэдэгдэлгүй гаргана.

5.7 Онцгой шаардлага

Энэ стандартын 5.7-д заасан бүх шаардлагад хамаарах сэдвээр өөрийн-зарласан мэдүүлэг, тайлбартай мэдэгдэл гаргаж болно. Тайлбартай аливаа мэдүүлэгт дараахь зүйлийг оруулна. Үүнд:

а) Төөрөгдүүлэхөөргүй, оноц сайтай байх;

MNS ISO 14021 : 2001

- b) Итгэл үнэмшил, нотолгоотой байх;
- c) Хамааралтай байх тухайлбал, бүтээгдэхүүн, тухайн бичигт зөвхөн өөрийнх нь буюу тохирохыг нь ашигласан байдал;
- d) Бүтээгдэхүүн нь иж бүрнээр буюу зөвхөн түүний бүрэлдэхүүн, эсвэл сав боодол, үйлчилгээний элемент бүр экологийн хувьд цэвэр болох тухай асуудлаар мэдүүлэгтээ тусгаж танилцуулах;
- e) Байгаль орчны асуудал буюу түүнийг цаашид сайжруулах ажлын төрлийг мэдүүлсэн байх;
- f) Байгаль орчны нэгдсэн өөрчлөлт бол ашигтай утгатайгаар хэлэхээр янз бүрийн томъёолол зүйг ашиглаж зарлахгүй байх;
- g) Үр дүнг буруу тайлбарлахгүй байх;
- h) Зөвхөн эцсийн бүтээгдэхүүнд холбоотой бус, мөн орчны нөлөөллийн бодит байдлын үйл явцын нэгийг ч гэсэн бууруулан зөв тогтоохын тулд мөн түүний “амьдрал”-ын мөчлөгт анхаарах;
Тайлбар: Энэ шаардлагагүй гэх нь “амьдрал”-ын мөчлөгийн үнэлгээг үүрэг болгохыг хэлж болно.
- i) Бүтээгдэхүүнийг батлахдаа тайлбарлалтгүйгээр буюу шаардлагатай цагт нь түүнийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж танилцуулах материалдаа тусгах;
- j) Мэдүүлэг нь байгаль орчныг сайжруулах талаар ямарваа нэгэн арга, гарцгүй тухай хүсэлт, тайлбарын аль нэгээр шууд байж болохгүй. Түүнчлэн байгаль орчны холбогдолтой бүтээгдэхүүний мэдүүлэг нь хэтрүүлэггүй байх;
- k) Хэрэв мэдүүлэг нь нэг бүрчлэн зохих шаардлагыг биелүүлсэн ч гэсэн, худалдан авагчаас буруу тайлбарласан буюу холбогдох баримтаар будлиан төөрөгдүүлэлд оруулах үйлдлийг хийж болохгүй;
- l) Бүтээгдэхүүний дамжлага(“амьдрал”)-ын турш тохиромжтой хэрэгжилт буюу байгаль орчны асуудлын аль аль нь гарах урсгалд хамаарах;
- m) Байгаль орчны мэдүүлэг болон тайлбартай мэдэгдлийг хамтад нь авч үзэхээр бол тодорхой зааж бичсэн байх;
- n) Байгаль орчны эрхэмлэх зүйлийг харьцуулан батлах буюу түүний сайжруулалт, онцлох асуудал, харьцуулсан үндэслэл нь тодорхой байх. Тухайлбал: Байгаль орчны сайжруулалтын арга хэмжээнд орчин цагийн нэр томъёо хэрэглэж, мэдүүлэгтээ дурдсан байх;
- o) Хэрэв буй болох, тэгэхдээ урьдчилан хаалттай бус асуудалд тулгуурласан, хэрэглэгчээс орчин үед нийцүүлэн сайжруулснаар мэдүүлэгээ үндэслэсэн хэмээн найдаж байх бөгөөд худалдан авагчаас энэ талаар удирдан зохицуулаагүйг танилцуулгад дурдсан байх;

- p) Бүтээгдэхүүний ангилалтай хэзээ нэгэн цагт нэгтгэсэн байлаа ч, цаашид түүний бүрэлдэхүүн хэсэг хэмээн тэдгээрт тулгуурлан хийж болохгүй;
- q) Шаардлагатай гэж үзвэл технологит гарсан өөрчлөлтийг тусгаж, түүний дээшлэлтийг дахин үнэлж байх, өрсөлдөөнт бүтээгдэхүүн, эсвэл бусад нөхцөл шалтгаанаас болж, мэдүүлэгийн нарийвчлал нь давтагдахыг үгүйсгэх аргагүй;
- r) Байгаль орчны нөлөөллийн уялдаа холбоо нь хаа нэг бүс нутаг, хязгаар, байранд учрах хамааралтай байх.

Тайлбар: Үйл явцад холбогдох мэдүүлэгийг хаана ч гаргахдаа үйлдвэрлэлийн үйл явцад байгаль нөлөөлөл хаана их удаан хугацаагаар үргэлжлэх байршилыг сонгох нь зүйтэй. Түүний хир хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх байдлаар нь оновчтой тогтоосон байна.

5.8 Байгаль орчны мэдүүлэг гаргаж, эко-тэмдэг хэрэглэх

5.8.1 Өөрийн зарласан байгаль орчны мэдүүлэг гаргахдаа албадлагын бус эко-тэмдэг хэрэглэвэл зохино.

5.8.2 Байгаль орчны мэдүүлэг гаргаж, эко-тэмдэг хэрэглэхэд, уг бүтээгдэхүүний нөхөн үйлдвэрлэлийн байдал энгийн, тоо хэмжээ тохиромж сайтай байна.

5.8.3 Байгаль орчны мэдүүлэгийн аль нэг маягт зориулж эко-тэмдэг хэрэглэх бөгөөд энэ нь байгаль орчны бусад мэдүүлэгийн дагуу олгож буй тэмдгээс ялгаатай.

5.8.3 Байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлснээр хэрэглэх тэмдгийг байгаль орчны нөлөөлөл байдлын үнэлгээ явуулж бүтээгдэхүүнд хамааралтай эко-тэмдэг хэрэглэх ажилтай андууран буруу ойлгож болохгүй.

5.8.4 Байгалийн орчны объект нь мэдүүлсэн объект болон ашиг тусын сонирхолыг нэгтгэж, уялдуулан нотолсон нь тодорхой тохиолдолд зөвхөн хэрэглэж байх хэрэгтэй.

Тайлбар: Өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний хамаарал бүхий байгаль орчны зарим асуудлын дагуу эко-тэмдэг хэрэглэснээр олон талын ашигтай байна. Байгаль орчны зарим асуудлаар зохих эко-тэмдгийг хэрэглүүлэх талаар мэдүүлэгчдийг дэс дараатай сайшаан дэмжих бөгөөд уг тэмдэглэгээний хувьд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхээргүй эко-тэмдгийг боловсруулж байна. Шинэ эко-тэмдгийн сонголтод оюуны өмчийн эрхийг зөрчихгүйгээр (өөрөөр хэлбэл хөндлөнгийн байгууллагаас уг тэмдгийн загварыг хүлээн зөвшөөрч бүртгэгдсэн) зөв шийдвэрлэсэн байна.

5.9 Мэдүүлэг буюу бусад мэдээлэл

5.9.1 Үг, тоо, буюу эко-тэмдгийг байгаль орчны тухайн эко-тэмдэгт нэмэлт мэдээлэл болгохоор тухайлбал, материалыг таньж тодорхойлох арга, хог хаягдлын заавар журам, эсхүл хортой ба анхааруулах зэргийг ашиглаж болно.

5.8.2 Үг, тоо, эсвэл аливаа таних тэмдгийг байгаль орчны биш бусад мэдүүлэгт зорилгогүй хэрэглэнэ. Харин байгаль орчны мэдүүлэгт тэдгээрийг хэрэглэснээс буруу зөрүү ойлгох явдал гардаг тул ашиглахгүй.

5.9.3 Энэ стандартын 5.10 дугаар зүйлд байгаль орчны эко-тэмдгийн тухай тодорхой заасан учраас компани, нэгтгэл, үйлдвэрийн бэлэгдэл тэмдэгт холбогдох тэмдгийн дүрс төрхийг өөрчилж болохгүй.

5.10.2 Ерөнхий зүйл

Олон улсын энэхүү стандартын дагуу онцлох тэмдгийн сонголт нь хүлээн зөвшөөрөх байдал, хэрэглэгээний өргөн хамрах хүрээ, гарцад тулгуурлана. Энэ нь тухайлагдаж авах гэсэн байгаль орчны бусад мэдүүлэгт эдгээр тэмдгийн давуу талыг танилцуулж болно. Зөвхөн “Мобиусын хүрд”-д түүнийг нэмэлт болгон оруулж тусгана. Олон улсын энэ стандартад онцгой бусад таних тэмдгээр заасныг төлөөлөн хэрэглэж болохгүй.

5.10.3 Мобиусын хүрд


5.10.2.1 Мобиусын хүрд нь гурван сумыг гурвалжин хэлбэрээр байрлуулан нар зөв эргүүлсэн байдлаар зурж, дүрсэлсэн тэмдэг байна. Энэ график тэмдгийн дүрсийг олон улсын ISO 7000 тоот стандартаар 1135 дугаарт дурдсан байдаг бөгөөд байгаль орчны мэдүүлэгийг зөвшөөрсөн тохиолдолд түүнийг хэрэглэнэ. Хаана ч, тэгэх тусмаа, уг тэмдэг нь тодорхой, тэс өөр ялгаатай байна.

Мобиусын хүрдийн зарим жишээг 1-р зургаар харуулж байна. Мобиусын хүрдийг хэрэглэх байдал, ашиглахтай холбогдуулан тавих шаардлагыг энэ стандартын 7 дугаар зүйлд нарийвчлан зааж тусгасан болно.

5.10.3.1 Мобиусын хүрдийг тухайн бүтээгдэхүүнд буюу түүний сав баглаа боодолд нь хэрэглэж болно. Хэрвээ тэмдэг нь бүтээгдэхүүнд буюу сав боодолд нь хаа нэгэн газар нь хэрэглэхэд ямар нэгэн төвөг бэрхшээлтэй бол түүнийг төлбөртэй мэдэгдэл байдлаар дагалдах баримт бичигт хэрэглэж болно.

5.10.2.3 Хэрэв тэмдэг нь тухайн мэдүүлэгт зориулан дахин боловсруулж ашиглах буюу дахин ашиглах чадамжийг илэрхийлэх бол энэ стандартын 7.7 ба 7.8 дугаар зүйлд заасан шаардлагаар Мобиусын хүрдийг хэрэглэвэл зохино.

5.10.3.2 Дахин боловсруулж ашиглах буюу дахин боловсруулагдах чадамжтай холбогдуулан зөвхөн мэдүүлэгт зориулан хэрэглэх Мобиусын хүрд нь энэ стандартын 7.7 ба 7.8 дугаар зүйлд тодорхойлон заасны дагуу байна.



1-р зураг.

6 Мэдүүлгийн шаардлагын нотолгоо баталгаа ба үнэлгээ

6.1 Мэдүүлэгчийн үүрэг хариуцлага

Мэдүүлэгч нь өөрийн зарласан байгаль орчны мэдүүлгийн шаадлагатай өгөгдлийн байдал болон үнэлгээг хариуцна.

6.2 Үнэлгээний арга зүйн найдвартай байдал

6.2.1 Мэдүүлгийг гаргах талаар чиглэлийн болон үнэлгээний арга хэмжээ нь уг мэдүүлгийг нотолж батлахуйц шаадлагатай үр дүнг дахин хийж гүйцэтгэхэд хэрэгжилтийг хүрэлцэхүйц хэмжээнд хүргэсэн байвал зохино.

6.2.2 Үнэлгээг бүрэн баримтжуулсан байхаас гадна энэ стандартын 6.5.2-т дурдсан мэдээллийг тухайн мэдүүлэгчээс зохих журмын дагуу хадгалах үүрэгтэй. Энэ нь зах зээлийн нөхцөлд уул бүтээгдэхүүний бүх дамжлага буюу “амьдрал”-ын мөчлөгийг нарийн тооцож, шалтгааныг нь ямар ч цаг мөчид үзэх боломжтойг харуулна.

Тайлбар: Удирдамж ёсоор найдвартай байдал, мөшгөх боломжийн талаар номзүйн мэдээллийн 11-т ишлэл хэрэглэснийг үзнэ үү.

6.3 Мэдүүлгийн харьцуулсан үнэлгээ

6.3.1 Мэдүүлгийн харьцуулалтыг дараахь хэд хэдэн аргаар үнэлнэ. Үүнд:

- a) Байгууллагын эзэмшлийн өмнөх үйл явц,
- b) Байгууллагын эзэмшлийн өмнөх бүтээгдэхүүн,
- c) Байгууллагын бусад үйл явц,
- d) Бусад байгууллагын бүтээгдэхүүн зэрэг болно.

Энэ мэдүүлгийн харьцуулсан үнэлгээг хийхдээ, зөвхөн дараахь тохиолдолд явуулна:

- холбогдох стандартыг батлаж хэвлэсэн, хэрэглэж буй буюу сорилтын туршилтын аргыг нь хүлээн зөвшөөрсөн (6.4-т үзнэ үү) ба,
- харьцуулж буй бүтээгдэхүүн нь бусад үйлдвэрлэгчдийн хувьд ижилхэн, адилхан зориулалттай зах зээлд нийлүүлэгдсэн байх хэрэгтэй.

6.3.2 Байгаль орчинд нөлөөлөлтэй бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгт холбогдох мэдүүлэгийн харьцуулалтад дараахь асуудлыг заавал оруулна:

- a) хэмжүүрийн ижилхэн нэгжийг хэрэглэхээр тоолж тооцох,
- b) ижилхэн нэгж, үүрэг функцэд тулгуурлах,
- c) хугацааны хувьд завсарлагын дээд хязгаарыг тохирох, үлгэрлэвэл хоёр сараар байх хэрэгтэй.

6.3.3 Харьцуулсан мэдүүлэгт тулгуурлах үндэслэл бол:

- a) Энэ тохиолдолд, тэдгээр үнэмлэхүй ялгаварыг хувь(%)-иар илэрхийлж чадна.

MNS ISO 14021 : 2001

Тайлбар: Дараахь жишээ нь хэмжилтэд холбогдох асуудлыг тодорхой болгоно. Дахин ашиглах чадамжийн 10 %-ийг 15% болгож өөрчлөхөд үнэмлэхүй ялгавар нь $10\% - 15\% = 5\%$, харин мэдүүлгээр бол нарийвчлал 50% болон өсч төөрөгдүүлж магадгүй.

b) Энэ тохиолдолд үнэмлэхүй (хэмжсэн нь) тоог сайжруулахтай холбогдуулан тэдгээрийг өсгөж болно.

Тайлбар: Дараахь жишээ нь үнэмлэхүй хэмжилтийг тайлбарлан тодруулна.

Байгаль орчны ажлыг сайжруулах талаар арван сарын хугацаанд хийхээр байсныг 15 сараар сунгасантай холбогдуулан тусгай аргачлалаар үнэмлэхүй тоон үзүүлэлтийг тооцохдоо: 15 сараас 10 сарыг хасаад зуун хувиар үржүүлж, 10 сардаа хувааж 50 % гарна. Үүнийг "өөрийн зарласан мэдүүлэгтээ "амьдрал"-ын мөчлөгийг 50 %-иар уртасгасан гэж" үзэж бичвэл зөв болно.

6.3.4 Мэдүүлэгтэй холбоо бүхий үнэмлэхүй мэдүүлэг нь будлиантуулах хамгийн их эрсдэлтэй учраас үнэмлэхүй мэдүүлгийн үг, өгүүлбэр бүрийг ойлгомжтой, тодорхой бичиж илэрхийлбэл зохих бөгөөд ингэхгүй бол мэдүүлэг биш болно.

6.3.5 Бүтээгдэхүүн болон түүний сав боодлыг сайжруулахдаа тус тусад нь мэдэгдэх ба түүнийг бүхэлд нь нэг удаагийн арга хэмжээ болгохгүй байвал зохино.

6.4 Арга зүйн сонголт

Үнэлгээний болон мэдүүлгийн арга зүйг батлан лавлахын тулд олон улс, хүлээн зөвшөөрсөн бусад стандартыг олон улсын хэмжээнд зөвшөөрөх боломжтой (эдгээр нь үндэсний ба бүс нутгийн) стандартыг оролцуулан авч үзэх, нэрийг нь заасан буюу шинжилгээний сэдэвт үйлдвэрлэл, худалдааны арга хамаарвал зохино. Хэрэв эдгээр аргууд нь аль хэдийнээ шаардлагатай бол мэдүүлэгчээс боловсронгуй болгон энэ стандартын 6-т болон бусад шаардлагад нийцүүлэх бөгөөд нэрийн задлан шинжилгээг явуулах боломжтой байна.

Тайлбар: Ном зүйн мэдээлэл (иш татаж хэрэглэсэн [12], [66])-д жагсаасан мэдүүлгээс заримыг нь олон улсын ба үндэсний зарим стандарт, тухайн үйлдвэрийн зарим онцлог, аргаас хамаарч сонгон хэрэглэнэ.

6.5 Мэдээлэлд хүрэх боломж

6.5.1 Байгаль орчны өөрийн зарласан мэдүүлэг бол зөвхөн бизнесийн мэдээлэлд итгэлээр дамжин хэрэгжих боломжгүй, зөвхөн нотолгоо баталгаа шаардлагатай гэж үзнэ. Мэдүүлгийг зөвхөн тэдгээр бизнесийн мэдээллээр нотолж батлахын тулд бас гаргадаггүй.

6.5.2 Мэдүүлэгч нь сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд уг мэдүүлгийг нотолж батлахын тулд олон нийтэд шаардлагатай мэдээлэл байх хэрэгтэй. Хэрэв нотолгооны мэдээлэл шаардлагагүй бол мэдүүлэг нь хүсэлт ёсоор учир шалтгааны зардалд (захиргааны гарах зардлыг нөхөхөд) хоног хугацаа, байршил, мэдүүлгийг үзэж, нотлон батлахад мэргэжлийн хүний шаардлагаас бас хамаарна.

6.5.3 Шаардлагатай мэдээлэлд хамгийн наад зах нь энэ стандартын 6.2-т заасны дагуу холбогдолтой гэж үзэж, дараахь асуудлыг оруулна. Үүнд:

a) ашигласан стандарт буюу аргын тухай ижилтгэсэн тодорхойлолт,

- b) хэрвээ эцсийн бүтээгдэхүүнд сорилт туршилт явуулж батлах боломжгүй бол баримтат нотолгоо байх,
- c) мэдүүлгийн нотолгоо баталгаанд зориулан эдгээрийг шаардлагатай газар нь хийх ба сорилт туршилтын үр дүн,
- d) гаднын харилцан хамааралгүй туршилт явуулсан байгууллага-талуудын нэр, хаяг,
- e) нотолгоо бол энэхүү стандартын 5.7 h) болон 5.7 г)-т заасан шаардлагын дагуу мэдүүлэгийг батлах,
- f) байгаль орчны зарласан мэдүүлэгт өөр бусад бүтээгдэхүүнтэй харьцуулбал ашигласан аргын тодорхойлолт, тэдгээр бүтээгдэхүүний сорилтын дүнг болон экологийн цэвэр гэдгийг өөрсдөө баталсан асуудлыг оруулна.

Тайлбар: Мэдүүлгийн талаар харьцуулалтад тавих шаардлагыг энэ стандартын 5.7-т зааж үзүүлсэн болно.

- g) Нотолгоо бол байгаль орчны өөрийн зарласан мэдүүлгийн нарийвчлал сайтай, үнэн зөв байх талаар мэдүүлэгчээс өөрийн үнэлэлт өгч баталгаа гаргах бөгөөд ингэхдээ мэдүүлгийн мөрдөх хугацааны туршид уул бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийн үе шатыг чанд харгалзан үзсэн байвал зохино.

7 Мэдүүлгийн сонголтод тавих онцгой шаардлага

7.1. Ерөнхий зүйл

7.1.1 Энэхүү стандартын 7 дугаар зүйл нь байгаль орчны өөрөө-зарласан мэдүүлэгт хэрэглэх нийтлэг нэр томъёоноос хязгаарлагдмал байдлаар ашиглахаар сонгон авч, уялдуулах боломжийг хангаж өгнө.

Мэдүүлэгчийн хариуцлагын талаар энэ зүйлийн дараахь зарчимд зааж үзүүлснээр таалагдах нэр томъёогоор сольж, асуудлыг сулруулах учиргүй, харин олон улсын энэ стандартын бусад тохиолдолд тавих шаардлагыг орлохгүй байна.

7.1.2 Энэ стандартын 7 дугаар зүйл дэх мэдүүлэг(үүд) бол байгаль орчны талаархи бусад мэдүүлэгээс хавьгүй илүү сайн хэмээн ойлгож болохгүй.Тэдгээрийг сонгох энэ зарчим, шалтгаан нь түүний ач холбогдлыг бус, тухайн байдлыг бодитойгоор өргөн ашиглах явдал байна. Эдгээр мэдүүлэг бол тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шат, хуваарилалт, ашиглалт, сэргээж хэрэглэх болон хаягдалтай холбогдуулан зохих хариулт өгч чадахаар байна.

Тайлбар: Дор дурдснаас сонголт хийж, “Байгаль орчны талаархи өөрийн зарласан мэдүүлэг”-тэй нийцүүлэх явдал чухал. Жишээлбэл:

- 1.2. *Исэлдэлт,*
- 1.3. *Доройтолт(хомсдолт),*
- 1.4. *Хэсэгчилсэн зохион байгуулалт,*
- 1.5. *Бүтээгдэхүүний “амьдрал”-ын мөчлөгийг уртасгах,*
- 1.6. *Нөхөн сэргээгдсэн эрчим хүч,*
- 1.7. *Дахин боловсруулж ашиглах,*

MNS ISO 14021 : 2001

- 1.8 . Дахин боловсруулагдах чадамж,
- 1.9 . Эрчим хүчний хэмнэлт,
- 1.10 Нөөцийн ашиглалтын хэмнэлт,
- 1.11 Усны хэмнэлт,
- 1.12 Дахин ашиглах ба нөхөн сэргээж сайжруулах,
- 1.13 Хаягдал бууруулалт.

7.2 Исэлдэлт

7.2.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүний үзүүлэлт, сав боодол буюу түүний бүрэлдэхүүн хэсэг нь биологийн өөрчлөлт, нэгэн төрлийн байдал ба ялзмаг маягийн бодис бүрдүүлэх.

7.2.2 Хязгаарлагдмал байдал

7.2.2.1 Бүтээгдэхүүн, сав боодол, тэдгээрийн бүтэц найрлага тус бүрийн талаар мэдүүлэг гаргахгүй, тухайлбал:

- a) Хөрсөнд нэмэлт хэрэглэснээр сөрөг нөлөөлөл үзүүлж, түүний үнэ цэнэ нь алдагдвал,
- b) Хортой агууламж буй бодисыг чөлөөлснөөр тухайн явцад болон хожим хойно нь байгаль орчинд ямар нэгэн химийн, физикийн задрал явагдвал,
- c) Тэдгээр тогтолцоон дахь бүтээгдэхүүн, эсвэл түүний бүтэц найрлага нь заавал шалгагдахаар байж, шалгуурт орох үнэлгээг мэдэгдэхүйц бууруулах бол,

7.2.2.2 Исэлдэлттэй холбогдол бүхий бүх мэдүүлэг нь дараахь тодорхой, хязгаарлагдмал нөхцөл байдалд хэрэгжинэ:

- a) Мэдүүлгээр бэлтгэсэн бордооны төрөлд багтаж байна уу, эсвэл процесс нь бордооны бүтэц найрлагыг тодорхойлох, эсхүл бордоо бэлтгэх төвийн буюу талбай дээрх төхөөрөмж, бүтээгдэхүүн нь бага исэлдэлттэй бүх тохиолдолд, шаардлагатай бол хязгаарлалтгүй байхыг тус тус нарийвчлан тогтооно.
- b) Хэрэв бүтээгдэхүүн бүхэлдээ исэлдэлтгүй бол мэдүүлгээр бордооны бүтэц найрлагын талаар исэлдэлтийг тусгайлан тодорхойлж болно. Хэрэв бүтээгдэхүүнийг хэрэглэгч нь бордооны бүтэц найрлагад тусгайлан шаардлага тавихгүй бөгөөд түүнийг хэрхэн яаж хийх талаар ойлгомжтой, тодорхой зааварчлагаар хангана.
- c) Хэрэв бүтээгдэхүүн нь гэрийн аргаар бэлтгэсэн бордоогоор, эсхүл түүнийг бэлтгэх төвийн, эсхүл талбай дээрх хэрэгслийн чухам алинд хамаарч буйг тухайн мэдүүлэгт нь тодорхойлох ба ямар нэгэн асуудал буюу эрсдэлийг нэгтгэж бичиж танилцуулна.

7.2.2.3 Хэрэв исэлдэлтийн байдал нь гэрийн аргаар бэлдсэн бордооны талаар мэдүүлэгт нэмэлт болгон дараахь шаардлагыг анхаарвал зохино. Үүнд:

а) Хэрэв сайтар боловсруулж бэлтгэсэн буюу сайжруулсан бүтээгдэхүүн нь исэлдэлтийн хувьд дунд зэргийн баталгаат шаардлагатай бол, эсвэл эцсийн бүтээгдэхүүн, түүний бүтэц найрлага нь исэлдэлтийн шууд үр дүн байх тохиолдолд албан ёсны нэмэлт мэдэгдэл гаргах бөгөөд ийм үед исэлдэлтийн талаар мэдүүлэг гаргахгүй,

б) Хэрэв бүтээгдэхүүн буюу түүний бүтэц найрлагад гэрийн аргаар бэлдсэн бордоо, материал, тоног төхөөрөмж(бордооны нэгжээс өөр бусад) буюу мэргэшил туршлага, гол төлөв гэр бүлийн хэмжээний аж ахуй эрхэлсэн магадлалгүй бол тэр талаар мэдүүлэг гаргахгүй,

7.2.2.4 Исэлдэлтийн холбогдолтой мэдүүлэг бол тухайн орчны шалгагчдын бусад арга хэрэгсэл гэхээсээ илүү, гол төлөв уг үйл явцаас хамаарч, дараахь зүйлд хариулт өгнө. Үүнд:

а) бүтээгдэхүүн, эсвэл сав боодол нь бордооны тийм зориулалт, арга хэрэгсэл нь худа лдан авагч, худалдагч, хэрэглэгчид хүлээн авах бол тэдгээрийг хаана ч худалдсан байж болно.

б) хэрэв бүтээгдэхүүнийг худалдан авагч байгууллага, худалдагч болон хэрэглэгчид тайлбартай мэдэгдэл нь хүлээн авахад зохимжтой бус гэж үзвэл тэдгээр арга, хэрэгслийн талаар хязгаарласан зохих арга хэмжээг ашиглана.

с) ерөнхий хязгаарлалтад “Бордоо бий болгох нөхцөл бүрдэх” нь тохиромжгүй бол тохирохгүй төхөөрөмжийг хязгаарлах явдлыг хэрэглэхгүй.

7.2.3 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлд заасны дагуу ойлгож явуулна.

7.3 Доройтолт(хомсдолт)

7.3.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүн, эсвэл сав боодлын үзүүлэлт нь онцгой шаардлагын журмаар өгөгдлийн үргэлжлэх цаг хугацааны туршид эрс буурна.

Тайлбар: Химийн бүтцэд өөрчлөлт ороход хүлээж авах чадвар(мэдрэмж)-ын үүрэг функцийг доройтолт(хомсдолт) бий болно.

7.3.2 Хязгаарлагдмал байдал

7.3.2.1 Доройтолтод хөрсний биологийн доройтолт болон газрын гадаргын муудалт(хөгшрөлт)-ыг оролцуулан хязгаарлагдмал байдлын бүх төрөлд дараахь зүйлийг ишлэл болгон хэрэглэнэ. Үүнд:

а) Доройтолтын байдлын талаархи мэдүүлэгийг зөвхөн тусгай сорилтын аргад, доройтолтын дээд түвшинг тогтоох болон туршилтын хугацааны туршид, мөн бүтээгдэхүүн буюу түүний бүрэлдэхүүн буюу бүтэц найрлагыг тодорхойлохтой холбогдуулан шалтгааныг тодруулах зорилгоор гаргана.

MNS ISO 14021 : 2001

- b) Байгаль орчинд хортой бодисыг ялгаруулахтай холбогдсон бүтээгдэхүүн, сав боодол, тэдгээрийн бүтэц найрлага, бүрэлдэхүүн хэсгийн талаар ямар нэгэн хомсдлын мэдүүлэгийг гаргахгүй байвал зохино.

7.3.3 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлд зааснаар ойлгож хэрэгжүүлнэ.

7.4 Хэсэгчилсэн зохион байгуулалт

7.4.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүний зохион бүтээлт, боловсруулалтын үзүүлэлт нь түүнийг хэсэгчлэн авч үзэх, эцэст нь түүний амьдралын мөчлөгийн ашигтай тал тухайлбал бүтэц найрлагыг болоод зохих бүррэлдэхүүн хэсгийг нь дахин ашиглах, эсвэл дахин боловсруулж ашиглах, эрчим хүчийг нөхөн сэргээх буюу зарим тохиолдолд бусад урсгал хаягдлаас нь болгоомжлох, сэргийлэх боломж олгоно.

7.4.2 Хязгаарлагдмал байдал

7.4.2.1 Хэсэгчилсэн зохион байгуулалтын төслийн холбогдолтой мэдэгдэлд тухайн бүтээгдэхүүн, түүний бүтэц найрлагыг болоод зохих хэсгийг нь дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах, эрчим хүчийг нөхөн сэргээх буюу зарим тохиолдолд бусад урсгал хаягдлын талаар тусгайлсан тайлбар мэдэгдлийг дагалдуулж болно.

7.4.2.2 Хэрвээ хэсэгчилсэн зохион байгуулалтын төслийн холбогдолтой мэдүүлэг нь дахин боловсруулж ашиглах зэрэг бусад мэдүүлэгийг дагалдуулахаар бол мөн дараахь шаардлагыг бусад мэдүүлэгт тавих болно.

7.4.2.3 Аливаа бүтээгдэхүүний хэсэгчилсэн зохион байгуулалттай холбогдолтой төслийн бүх мэдүүлэгээр худалдан авагчаас буюу хэрэглэгчээс хэсэгчилэн зохион байгуулж хийсэн үү, эсвэл түүнийг мэргэжилтнүүдээс ийнхүү хийж буцаасан уу гэдгийг зөв тогтоох хэрэгтэй.

7.4.2.4 Хэрэв бүтээгдэхүүнийг хэсэгчилсэн зохион байгуулбал үйл явц нь дараахь асуудалд анхаарлаа хандуулбал зохино. Үүнд:

- a) Цуглуулан хуримтлуулах буюу юу ч хийх боломжгүй болох нь худалдан авагч, худалдагч, хэрэглэгчийн хүлээн авах боломжтой бол тэдгээрийг хаана ч худалдсан байж болно.
- b) Хэрэв тийм бүтээгдэхүүнийг худалдан авагч байгууллага, худалдагч буюу хэрэглэгчдэд тайлбартай мэдэгдэл нь хүлээн авахад зохимжтой бус гэж үзвэл тэдгээр арга хэрэгслийн талаар хязгаарласан тохирох арга хэмжээг ашиглана.
- c) Ерөнхий хязгаарлалтад “Хэсэгчилэн зохион байгуулах нөхцөл бүрдүүлэх” нь ая таагүй бол холбогдох арга хэрэгслийг хязгаарлах явдлыг авч хэрэглэхгүй.

7.4.2.5 Бүтээгдэхүүнийг хэсэгчилэн зохион байгуулахдаа түүнийг худалдагч, гол худалдан авагч буюу хэрэглэгч нь ашигласан арга, хэрэгслийг нарийвчлан авч үзэж, зохих мэдээллийг дагалдуулсан байна.

7.4.2.6 Худалдагч, гол худалдан авагчаас бүтээгдэхүүнийг хэсэгчилэн зохион байгуулахтай холбогдсон асуулаар мэдүүлэгийг зөвхөн дараахь тохиолдолд гаргана. Үүнд:

- a) дагнасан арга хэрэгсэл буюу магадлан шүүлт шаардахгүй; болон
- b) бүтээгдэхүүний хэсэгчилэн зохион байгуулсан аргын болон бүрэлдэхүүн хэсгийг дахин ашиглах, дахин боловсруулж ашиглах, нөхөн сэргээх, эсвэл хаягдлын талаар тодорхой мэдээллээр хангана.

Тайлбар: ОУСБ/ОУЦТК-ын 14 тоот арга зүйн удирдамжид хэрэглэгчийг мэдээллээр хангах журмын талаар тусгасныг үзнэ үү.

7.4.2.7 Мэргэжилтнүүдээс тухайн бүтээгдэхүүнийг хэсэгчилэн зохион байгуулж, шаардагдах төхөөрөмж, арга хэрэгслийн талаархи мэдээллийг нарийвчлан үзэж хэрэгжүүлнэ.

7.5 “Амьдрал”-ын мөчлөг(үе)-ийг уртасгах

7.5.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүний бөх батыг уртасгах буюу гол шинж чанарыг нь сайжруулахын аль нэгэнд тулгуурлан ашиглалтын хугацааг уртасгаснаар хаягдлыг багасгах буюу нөөц ашиглалтыг бууруулахад үр дүн гарна.

7.5.2 Хязгаарлагдмал байдал

7.5.2.1 “Амьдрал”-ын мөчлөгийг уртасгахтай холбогдсон бүх мэдүүлэг нь хязгаарлагдмал байдлаар хэрэгжинэ. Харьцуулалтын мэдүүлэгт энэ талаар тавих шаардлагыг 6.3 дугаар зүйлд заасан.

7.5.2.2 “Амьдрал”-ын мөчлөгийн холбогдолтой мэдүүлэгийг гаргахдаа тухайн бүтээгдэхүүний үндсэн шинж чанарыг сайжруулах буюу түүнийг дээшлүүлэх талаар тусгай мэдээлэлд үндэслэвэл зохино.

7.5.2.3 Бүтээгдэхүүний эдэлгээний хугацааг уртасгах талаархи мэдүүлэг нь уг бүтээгдэхүүний тухай өөрийн зарласан хугацааны туршид бөх батын удаан эдэлгээт чанарыг сайжруулах буюу түүнийг хувь(%)-иар илэрхийлэх ба тоо хэмжээг хэмжихэд нь (өөрөөр хэлбэл эвдрэл осол гарахаас өмнөх ажиллагааны тоон давталт) буюу мэдүүлэгийг нь дэмжихэд үндэслэлтэй байна.

7.5.3 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлд зааснаар ойлгож явуулна. Нэмэлт богоход, амьдралын мөчлөгийн уртасгалтын дундаж үе нь 6.4 дүгээр зүйлд заасан шиг, стандартын үнэлгээ, статистикийн аргын дагуу хэмжилт хийж гүйцэтгэнэ.

7.6 Нөхөн сэргээгдэх эрчим хүч

7.6.1 Нэр томъёоны хэрэглээ

Хог хаягдлыг хаях, цуглуулахыг удирдлагын ажиллагаагаар өөрчилж, түүгээр нөхөн сэргээх болон эрчим хүчийг гаргаж авахтай холбогдол бүхий нэгж бүтээгдэхүүний аливаа шинж чанар (үзүүлэлт).

Тайлбар: Энэ эх бичвэрт дурдсанаар нөхөн сэргээгдэх эрчим хүчийг “бүтээгдэхүүн” гэж ойлгоно.

7.6.2 Хязгаарлагдмал байдал

Мэдүүлэг гаргахын тулд, үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнээс нөхөн сэргээх эрчим хүчийг гарган ашиглах, түүнийг энэ стандартын 7.6.3-т заасны дагуу үнэлгээгээр тооцох бөгөөд дараахь хязгаарлагдмал нөхцөлд ашиглана. Үүнд:

a) Материалын хаягдлыг цуглуулах ба нөхөн сэргээгдэх эрчим хүч болгон хувиргах нь олон талын ашиг тустай. Энд үйлдвэрлэл, гэрийн хороолол, орон сууц, нийтийн ахуйн үйлчилгээний болон бизнесийн үйл ажиллагаагаар бий болсон хог новш, материалын хаягдал цөм хамаарна.

b) Нөхөн сэргээгдэх эрчим хүчний холбогдолтой мэдүүлэг гаргахын өмнө тухайн мэдүүлэгч нь энэ удирдлага, хяналтын үйл ажиллагаанаас байгаль орчинд хортой, сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэж баталгаа гаргах учиртай.

c) Хаягдлын төрөл, тоо хэмжээ нь нөхөн сэргээж ашиглагдах боломжтойг мэдэгдсэн байна.

7.6.3 Үнэлгээний арга зүй.

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлд заасны дагуу ойлгож хэрэгжүүлнэ. Нэмэлт болгоход, нөхөн сэргээгдэх эрчим хүчний асуудлаар дараахь тооцооны аргыг хэрэглэж болно.

a) Зөвхөн энэ $(R - E > 0)$ тохиолдолд өөрийн мэдүүлэгийг гаргаж болно.

б) Эрчим хүчний цэвэр хэмнэлтийн холбогдох мэдүүлэгийг дараахь байдлаар тооцно.

Сэргээгдэх цэвэр эрчим хүч (%-иар) = $\frac{(R-E)}{(R-E)+P} \times 100$;

Энд : P - үйлдвэрлэлийн эрчим хүчний анхны эх үүсгүүр ашиглалтын үйл явцад бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан эрчим хүчний дүн,

R - сэргээгдэх эрчим хүчний нийт дүн,

E - эрчим хүчний анхны эх үүсгүүрийг ашигласнаас түүнийг сэргээх явцад гаргаж авах сэргээгдсэн эрчим хүчний дүн,

7.7 Дахин боловсруулж ашиглах

7.7.1 Нэр томъёоны хэрэглээ

Хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд юмуу, хаягдлын урсгалаас түүнийг цуглуулан хуримтлуулж, боловсруулах замаар эх бүтээгдэхүүн, түүхий эд, материалын хэлбэрт оруулахаар эргүүлэн ашиглаж болохуйц бүтээгдэхүүн, түүний бүрэлдэхүүн хэсэг, сав боодлын шинж чанар.

Тайлбар: Материалыг дахин боловсруулж ашиглах явдал бол хаягдлыг хязгаарлан зогсоох талаархи стратегийн чухал чиглэл мөн. Стратегийн зөв сонголт нь нутаг дэвсгэрийн хэмжээнд нөлөөлөл, ялгааг гарган авч, учир шалтгааныг хэрхэн яаж тооцож, тодорхойлохоос ихээхэн хамааралтай байна.

7.7.2 Хязгаарлагдмал байдал

Хэрэв бүтээгдэхүүн, сав боодол, бүрэлдэхүүн хэсгийн хаягдлын хуримтлал бий болгох буюу дахин боловсруулж ашиглах зорилго нь худалдагч, үндсэн худалдан авагч буюу хэрэглэгчийн харьцаанд хүлээн авахад тохиромжтой бус бол уул бүтээгдэхүүнийг худалдсаны ойролцоох газарт дараахь асуудлыг хандуулах хэрэгтэй. Үүнд:

- a) Дахин боловсруулж ашиглахтай холбогдуулан хязгаарлагдмал мэдүүлэгийг ашиглах,
- b) Хязгаарлагдмал мэдүүлэг нь хуримтлалын цуглуулсан зүйлийг зохих газарт нь дамжуулан зөөж ашиглахаар хязгаарлаж өгөх,
- c) Ерөнхий хязгаарлалтад “Дахин боловсруулж ашиглах нөхцөл бүрдүүлэх” нь тохиромж муутай тохиолдолд холбогдох арга хэрэгслээр хязгаарлалт хэрэглэхгүй.

7.7.3 Эко-тэмдгийг ашиглах

7.7.3.1 Дахин боловсруулж ашиглах талаар мэдүүлэг гаргахдаа албадлагын бус хэлбэрээр эко-тэмдэг хэрэглэнэ.

7.7.3.2 Дахин боловсруулж ашиглах талаар мэдүүлэгтэй холбогдуулан албадлагын бус эко-тэмдгийг хэрэглэхдээ энэ стандартын 5.10.2-т тодорхойлсон Мобиусын хүрдийг ашиглана.

7.7.3.3 Энэ стандартын 5.10.2-т тодорхойлж заасан Мобиусын хүрдийн дахин боловсруулж ашиглах талаархи мэдүүлэг нь тоо, хувь(%)-гүй байвал зохино.

7.7.3.4 Энэ стандартын 5.6-т дурдснаар тайлбартай мэдүүлэг нь албадлагын бус хэлбэртэй байна.

7.7.3.5 Тайлбартай мэдүүлэгт уг материалын таництай холбогдсон кодчиллын тодорхойлолтыг оруулж болно.

7.7.4 Үнэлгээний арга зүй

Энэ стандартын 6 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээг ойлгож явуулна. Мэдээлэл нь энэ стандартын 6.5-т дурдсан ёсоор дараахь нотолгоог оруулна. Үүнд:

MNS ISO 14021 : 2001

- a) Эх үүсгүүрээс материалыг цуглуулж, ялган ангилах нь дахин боловсруулж ашиглахад худалдагч, гол худалдан авагч болон хэрэглэгчид үнэнхүү хүлээн авч болох ижилхэн тохиромжтой харьцааг бий болгосон байх,
- b) Дахин боловсруулж ашиглах төхөөрөмж нь материалыг цуглуулж байрлуулахад тохиромжтой байх,
- c) Хаягдлыг цуглуулж, дахин боловсруулж ашиглахтай холбогдсон бүтээгдэхүүнд мэдүүлэг гаргах.

7.8 Дахин болосруулагдах чадамж

7.8.1 Нэр томъёоны хэрэглээ

7.8.1.1 Дахин боловсруулагдах чадамж болон түүний нэгтгэсэн томъёолол нь дараахь зүйлүүдтэй уялдаатай байна.

a) Дахин боловсруулагдах чадамж

Бүтээгдэхүүн буюу сав боодлын материалыг дахин боловсруулж ашиглах, масс(цул)–аар илэрхийлсэн зохих харьцаа. Зөвхөн бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө буюу хэрэглэсний дараа л уг материалын дахин боловсруулагдах чадамжийг тодорхой мэдэж шийдвэрлэх бөгөөд дараахь нэр томъёог хэрэглэнэ. Үүнд:

1) Ашиглалтын өмнөх материал

Үйлдвэрлэлийн явцад гарах хаягдал материалыг зайлуулна.Материалыг дахин боловсруулахдаа дахин засварлах, гологдол, үйлдвэрлэлийн зарим явцад гарах эвдрэлээс үүсэх зүйлийг хасч тооцно.

2) Ашигласны дараахь материал

Аливаа худалдаа, үйлдвэрлэл, байгууллагаас тухайн бүтээгдэхүүнийг удаан биш хугацаагаар зориулалтаар нь ашиглаж дуусснаар хаягдал материал бий болно. Энд хуваарилалтаас буцаасан материалыг ч оруулна.

b) Дахин боловсруулж ашиглах материал

Хаягдлыг материал болгон ашиглахгүй боловч, түүнийг цуглуулж нөхөн сэргээгдэх эрчим хүчийг гарган авахаар үйлдвэрт оруулахдаа шинэ анхдагч материалын оронд буюу дахин боловсруулж ашиглах буюу үйлдэрлэх ажиллагааны үеэр [дахин мэдүүлэх] учиртай.

c) Нөхөн сэргээгдэх[дахин мэдүүлэх] материал

Үйлдвэрт оруулж эцсийн бүтээгдэхүүн болгох, улмаар түүний бүтэц бүрэлдэхүүнд ашиглахаар материалыг нөхөн сэргээж [дахин мэдүүлэх] материал болгоно.

Тайлбар 1. А. хавсралтаар материалыг нөхөн сэргээж ашиглах талаархи диаграммыг үзүүлсэн болно.

Тайлбар 2. Олон улсын энэ стандартын зорилго нь “нөхөн сэргээж ашиглах” ба “дахин мэдүүлэх” илэрхийлэл нь ижил төсөөтэй, уялдаатай ойлголт, гэхдээ зарим улс оронд нэгдмэл байдлаар ойлгоно, заримд нь бол тэгэж хэрэглэдэггүй явдал бий.

7.8.1.2 Материалыг дахин боловсруулж ашиглах явдал бол хаягдлыг хязгаарлах стратегийн зөвхөн нэг л чиглэл байна. Стратегийн ийм сонголт нь тухайлбал, энэ сонголтод нутаг дэвсгэрийн нөлөөллийн ялгаа, шалтгаан, тооцооноос гол нь хамаарна. Дахин ашиглалтын чадамж өндөр хувь(%)–тай байгаа нь байгаль орчинд нөлөөлөл бага байна гэж ойлгохгүй бөгөөд ийм хандлагыг авч үзэх нь зүйтэй гэж үзнэ. Яагаад гэвэл, үүнээс дахин боловсруулагдах чадамжийн тухай мэдүүлэг, тухайлбал тодорхойлсны дагуу ашиглах болно. Тайлбар: Энэ стандартын 5.7–д бичсэн шаардлагыг анхаарах шаардлагатай.

7.8.2 Хязгаарлагдмал байдал

7.8.2.1 Дахин боловсруулж ашиглах чадамжийн талаар мэдүүлэг гаргахдаа уг материалын ашиглалтын чадамжийг нь хувь(%)–иар гаргаж албан ёсоор мэдэгдэнэ.

7.8.2.2 Бүтээгдэхүүн, сав боодлын материал нь дахин боловсруулагдах чадамжийн хувь (%) нь тусдаа илэрхийлэгдэх бөгөөд нэг удаагийн арга хэмжээ болгох ёсгүй.

7.8.3. Эко-тэмдгийг хэрэглэх


7.8.3.1. Дахин боловсруулагдах чадамжийн талаар мэдүүлэг гаргаж эко- тэмдэг хэрэглэх нь албадлагын бус байдлаар хэрэгжиж болно.

7.8.3.2. Дахин боловсруулж ашиглах талаар мэдүүлэг хэрэглэхээр бол Мобиусын хүрд нь “X %”–иар илэрхийлсэн үзүүлэлтээр албан ёсоор мэдэгдэх бөгөөд “X” нь ашиглагдах чадамжийг нотлон илэрхийлж, энэ стандартын 7.8.4–т зааснаар бүх тооцоог хийсэн байна. “%”–иар илэрхийлэх үзүүлэлт тоог Мобиусын хүрдийн дотор талд, эсвэл гадна талын нэгэнд нь бичсэн байна. Жишээ болгож, үүнийг 2–р зургаар үзүүлж байна. Хувь (%) –иар үзүүлж, Мобиусын хүрдтэй хамтад нь бичсэн тоог (“X %”–иар гаргасан нь) дахин боловсруулагдах чадамжийн холбогдолтой мэдүүлэгийг илэрхийлнэ.

7.8.3.3 Дахин боловсруулагдах чадамжийн хувь(%) нь хамгийн бага “X %” –иар буюу хамгийн их “X %”–иар гэж нарийвчлан илэрхийлсэн байна.

7.8.3.4 Энэ стандартын 5.6–г баримтлан тайлбартай мэдэгдлийг албадлагын бус байдлаар хэрэглэхийг зөвшөөрнө.

7.8.3.5 Дараахь эко-тэмдгийг тухайн материалын таниц тодорхойлолтод дагалдуулсан байж болно.



2-р зураг-Дахин боловсруулж ашиглах чадамжийн тухай “Мобиусын хүрд” авч хэрэглэх талаар мэдүүлэг гаргахдаа тоо хэмжээг зааж илэрхийлэх жишээ(нүүд)

7.8.4 Үнэлгээний арга зүй

7.8.4.1 Үнэлгээг 6 дугаар зүйлд заасны дагуу ойлгож явуулна. Нэмэлт болгоход, дахин боловсруулж ашиглах чадамжийг дор үзүүлснээр тооцож, тоог хувь(%) -иар илэрхийлнэ. Бүтээгдэхүүн, сав боодол бүрт дахин боловсруулж ашиглах чадамжийг шууд хэмжих арга замгүй бол уг материалыг үйлдвэрт оруулсаны дүнд хэрхэн алдагдах болон бусад алдагдлыг тооцож, дараахь томъёог ашиглана.

$$X (\%) = \frac{A}{P} \times 100 ;$$

Энд: **X** - дахин ашиглах чадамж, %-иар,
A - дахин боловсруулагдаж ашиглах материалын масс,
P - бүтээгдэхүүний масс,

Тайлбар: А хавсралтад дахин боловсруулж ашиглах материал, лавлагааны тооцооны талаархи ангилалын бүдүүвчийг цаашид үзэх болно.

7.8.4.2 Дахин боловсруулж ашиглах материалын эх үүсгүүр, тооны нотолгоо баталгааг худалдааны баримтжуулалт ба байгаа бусад тайланг ашиглах замаар чиглүүлнэ.

7.9 Эрчим хүчний хэмнэлт

7.9.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүний гүйцэтгэл, функци нь ижил төрлийн бүтээгдэхүүн, адил төсөөтэй функцитай харьцуулахад эрчим хүчний нийт зарцуулалтын бууралт.

Тайлбар: Эрчим хүчний хэмнэлтийн талаархи мэдүүлэг эрчим хүчний үр ашиг, эрчим хүчний хамгаалалт буюу эрчим хүчний хадгалалтын нийт хэрэглээг үнэн зөв илэрхийлнэ.

7.9.2 Хязгаарлагдмал байдал

7.9.2.1 Эрчим хүчний хэмнэлтийн талаархи бүх мэдүүлэгийг хязгаарлагдмал хүрээнд хэрэглэнэ. Уг эрчим хүчний хэмнэлтийн талаар харьцуулсан мэдүүлэгийг 6.3-т заасан шаардлагад хамаарна.

7.9.2.2 Эрчим хүчний хэмнэлтийн талаархи бүх мэдүүлэгийг бүтээгдэхүүний ашиглалт болон хүргэж өгөх үйлчилгээнд түүнийг хэрхэн бууруулахад тулгуурлаж гаргана.

7.9.3 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлийн дагуу ойлгож явуулна. Нэмэлт болгоход, эрчим хүчний хэмнэлтийг бүтээгдэхүүн бүрт стандартын тогтоосон зохих арга болон статистик ажиллагааны дундаж өртөг зардал, тооцоонд тулгуурлан хэмжилт хийнэ.

7.10 Нөөцийн хэрэглээг бууруулах

7.10.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүн, сав боодол буюу бүрэлдэхүүн хэсгийг худалдаалах, хуваарилахад хэрэглэх материал, эрчим хүчний хэмнэлт, усны нийт зарцуулалт багасах
Тайлбар: Нөөцийн хэрэглээг бууруулах талаархи мэдүүлэгийг 7.9 ба 7.11-т заасны дагуу бүтээгдэхүүнд эрчим хүч, ус зарцуулалттай холбогдуулан гаргана.

7.10.2 Хязгаарлагдмал байдал

7.10.2.1 Нөөцөд эрчим хүч, уснаас гадна түүхий эд, материал орно.

7.10.2.2 Нөөцийн хэрэглээг бууруулахтай холбогдсон бүх мэдүүлэг нь хязгаарлагдмал хүрээнд хэрэгжинэ.

7.10.2.3 Бүтээгдэхүүн, сав боодлын нөөцийн ашиглалтын хэрэглээг бууруулах асуудлыг тус бүрд нь албан ёсоор мэдэгдэх бөгөөд нэгтгэж нэг арга хэмжээ болгож хийхгүй.

7.10.2.4 Нөөцийн ашиглалтын хэрэглээг бууруулах талаархи мэдүүлэг нь хэрхэн яаж бууруулсныг хувь (%) -иар илэрхийлсэн нэр томъёог хэрэглэнэ.

7.10.2.5 Нөөцийн ашиглалтын хэрэглээний талаар мэдүүлэг гаргавал нөөцийн төрөл бүрт нь тайлбартай мэдэгдэл хэрэглэнэ.

7.10.2.6 Нөөцийн ашиглалтыг бууруулахтай холбогдуулан гаргасан мэдүүлэгийн үр дүн бусад нөөцийг нэмэгдүүлэхээр бол тэдгээр нэмэгдүүлсэн нөөц, хувийг тайлбартай мэдэгдлээр илэрхийлж албан ёсоор бичсэн байна.

7.10.2.7 Нөөцийг бууруулах талаар эхний хоёр сарын турш ахиц амжилтад хүрвэл, тухайн мэдүүлэгийг бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа буюу зохион бүтээлт, боловсруулалт, хуваарилалтад тулгуурлан нөөцийг бууруулах талаар үнэлгээний тооцоог хийж, үндэслэл болгосон байна.

MNS ISO 14021 : 2001

7.10.2.8 Нөөцийн ашиглалтад өөрчлөлт гарсан тохиолдолд холбогдох нөөц тус бүрийг тус тусад нь тооцож байна.

7.10.3 Үнэлгээний арга зүй

Энэ стандартын 6 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээг ойлгож явуулна. Нэмэлт болгоход, энэ стандартын 7.10.2.7-т заасныг хасч, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нэг бүрийн нөөцийн зарцуулалт бол түүнийг үйлдвэрлэлд оруулж хоёр сарын үйлдвэрлэлийн туршийн хугацаанд нь хувааж гаргана. Нөөцийн ашиглалтыг бууруулах нормыг хувиар (U %) тооцохдоо нэгж бүтээгдэхүүний хоёр сарын туршид хэрэглэсэн бол дараахь томъёог ашиглаж болно.

$$U (\%) = \frac{(I-N)}{I} \times 100 ;$$

Энд: U - нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нөөцийн зарцуулалт, хувиар
I - нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нөөцийн анхны зарцуулалт,
N - нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нөөцийн шинэ зарцуулалт,

7.11 Ус хэмнэлт

7.11.1 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүний гүйцэтгэл, үүрэг функцийн усны ашиглалт, зарцуулалтыг адил үүрэгтэй бусад бүтээгдэхүүнтэй мөн түүний үзүүлэлтийг харьцуулж, усны зарцуулалтыг бууруулсан байдал

Тайлбар: Усны хэрэглээг бууруулах мэдүүлэгээр усны үр ашиг, усны хадгалалт буюу усны хамгаалалтыг илэрхийлнэ.

7.11.2 Хязгаарлагдмал байдал

7.11.2.1 Усыг үр дүнтэй ашиглах буюу түүний зарцуулалтыг бууруулахтай холбогдсон бүх мэдүүлэгийг хязгаарлагдмал байдлаар гаргана. Усны хэмнэлтийн талаархи харьцуулсан мэдүүлэгийг энэ стандартын 6.3-ын шаардлагад нийцүүлнэ.

7.11.2.2 Бүтээгдэхүүнд хэрэглэх усны хэмнэлтийн талаархи мэдүүлэгт усны ашиглалтыг хэрхэн яаж бууруулсныг үндэслэл болгож гаргана. Тэр нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ажиллагаанд хэрэглэх усны бууруулахыг оруулахгүй.

7.11.3 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлийн дагуу ойлгож явуулна. Нэмэлт болгоход, усны хэмнэлтийг бүтээгдэхүүн нэг бүрээр зохих арга, тогтоосон стандартын дагуу болон статистик ажиллагааны дүнд дундаж тооцоог хийж, хэмжиж гаргана. Арга сонголт нь 6.4 дугаар зүйлийн дагуу хийвэл зохино.

7.12 Дахин ашиглах ба сэргээх

7.12.1 Нэр томъёоны хэрэглээ

7.12.1.1 Дахин ашиглах

Ижилхэн зориулалтаар, амьдралынх нь мөчлөгөөр эргүүлэн хэрэглэх буюу ашиглахаар төсөл гүйцэтгэж хэрэглэх бүтээгдэхүүн буюу сав боодлын шинж чанар

7.12.1.2 Сэргээх

Адилхан эсвэл ижил төсөөтэй бүтээгдэхүүнийг нэг биш удаа, хангалттай тоо хэмжээгээр, гарал үүслийн маяг хэлбэрт нь нэмэлт ажиллагаа хийхгүйгээр, химийн цэвэрлэгээ, угаалгын талаар тавих шаардлагыг оруулахгүй ашиглагдах бүтээгдэхүүн, эсвэл сав боодлын шинж чанар

7.12.2 Хязгаарлагдмал байдал

7.12.2.1 Бүтээгдэхүүнгүй, сав боодолгүй асуудлаар дахин ашиглах буюу сэргээх талаар мэдүүлэг гаргахдаа дахин ашиглах эсвэл түүний гарал үүслийн зориулалтыг шинэчлэн дүүргэх зорилгоор уг мэдүүлэгийг гаргаж болно.

7.12.2.2 Зөвхөн нэг нэрийн бүтээгдэхүүн буюу сав боодлыг дахин ашиглах буюу сэргээх талаархи мэдүүлэгийг ямар тохиолдолд гаргах вэ гэвэл:

- a) Тухайн бүтээгдэхүүн буюу сав боодол нь цуглуулж ашиглагдах, дахин ашиглах, эсвэл түүнийг шинэчлэн дүүргэхтэй холбогдсон хөтөлбөрийг мөрдөж буй бол, эсхүл
- b) Ашиглаж буй арга хэрэгсэл, эсвэл бүтээгдэхүүнийг худалдан авагчаас нь ашиглах, дахин ашиглах эсхүл шинэчлэхээр зөвшөөрөл өгсөн бол.

7.12.2.3 Бүтээгдэхүүн, сав боодлыг цуглуулж, ашиглах, эсвэл дахин ашиглах, эсхүл түүнийг дүүргэн шинэчлэх зориулалтаар нь хүлээн авахад худалдан авагч, гол худалдагч буюу хэрэглэгчид тохиромжтой бус тохиолдолд худалдагдсан байршилтай бол уг мэдүүлэгийг дор дурдснаар гаргана.

- a) Дахин ашиглах буюу дүүргэх замаар дахин шинэчлэх талаар хязгаарлагдмал мэдүүлэгийг ашиглана.
- b) Хаягдлыг цуглуулах хөтөлбөр буюу төхөөрөмжийн холбогдох зөөвөрлөлт нь хязгаарлагдмал боломжтой бол хязгаарлагдмал мэдүүлэг гаргана.
- d) “Дахин ашиглах /дахин дүүргэж шинэчлэх нөхцөл бүрдэх”-ийг ерөнхийлж, хаягдлыг цуглуулах хөтөлбөр, холбогдох нөхцөл байдалд хязгаарлалт нь тохиромж муутай бол зөөвөрлөхгүй.

7.12.3 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлийн дагуу ойлгож явуулна. Нэмэлт болгоход, 6.5-т чиглүүлэн заасан мэдээлэлд дараахь нотолгоог оруулна. Үүнд:

MNS ISO 14021 : 2001

- a) Мэдүүлэг нь дахин ашиглах буюу шинэчлэн ашиглах гэж буй бүтээгдэхүүнд гаргана.
- b) Энэ дахин ашиглах буюу шинэчлэн ашиглах төхөөрөмжтэй гэж үзсэн бүтээгдэхүүнд л уг мэдүүлэгийг гаргана.
- c) Дахин ашиглах буюу шинэчлэн ашиглахтай холбогдон шаардагдах төхөөрөмж нь уг бүтээгдэхүүн худалдан авагч, худалдагч буюу хэрэглэгчид хүлээн авахад адилхан, тохиромжтой байна.

7.13 Хаягдлыг бууруулах

7.13.2 Нэр томъёоны хэрэглээ

Бүтээгдэхүүн, үйл явц, сав боодолд өөрчлөлт оруулсаны үр дүнгээр хог хаягдлын гарц, материалын (масс) тоо хэмжээ бууралт(багасалт)

Тайлбар: Үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас ус, агаар, хөрсөнд хаягдах бүх зүйлийг оруулж болно.

7.13.3 Хязгаардлагдмал байдал

7.13.3.2 Хаягдлыг бууруулахтай холбогдсон бүх мэдүүлэг нь хязгаарлагдмал байна.

7.13.3.3 Бүтээгдэхүүн, сав боодлын талаархи хаягдлыг бууруулах нь үйлдвэрлэл, хуваарилалт, ашиглалт болон хаягдлын үе шатанд багасгах явдлыг оруулна.

7.13.2.3 Хаягдлыг бууруулахтай холбогдсон мэдүүлэг нь зөвхөн усанд хаягдах агуулга, хөрсний бохирдуулалтыг багасгаад зогсохгүй, мөн үйл ажиллагаанаас гарах хаягдлын талаархи мэдэгдэлд бохирдлыг нь бууруулах явдал ч хамаарна.

7.13.2.4 Хаягдлыг бууруулах ажиллагааны тооцоонд материал дахин боловсруулж буй ажиллагааны үе тухайлбал, дахин боловсруулалт,

7.13.2.5 Хаягдлын эх үүсвэрээс хаягдлыг хэн нэгэн зохих хэрэглэгчид дамжуулахдаа түүнийг зориулалтаар нь зохистой ашиглах, урсгал, байрлуулалттай холбогдуулан мэдүүлэг гаргаж болно.


7.13.4 Үнэлгээний арга зүй

Үнэлгээг энэ стандартын 6 дугаар зүйлд заасны дагуу ойлгож явуулна.

Нэмэлт болгоход, хаягдлыг бууруулах талаархи дүнг жинхэнэ байвал зохих материалын балансад үндэслэн хаягдлыг тооцно.

А.Хавсралт(зөвлөмжийн)

Дахин боловсруулж ашиглах тогтолцоонд хамаарах нарийвчилсан диаграмм



Дахин боловсруулж ашиглах чадамж $\{ X \% = (A / P) \times 100 \}$;

Үйлдвэрлэлийн ажиллагаанд зарим материалыг сэргээж авах (дахин мэдүүлэх замаар) оруулах тухайлбал дахин боловсруулж ашиглах, эсвэл энэ тогтолцоонд “Дахин боловсруулж ашиглах процесс”-гүйгээр тусад нь гүйцэтгэх эсэхийг тодруулна. Үүнийг хийхдээ дагавар бүтээгдэхүүн болон хаягдал болтол нь энэ үйлдвэртээ ашиглана. Эдгээр дагавар бүтээгдэхүүн, хаягдал нь дахин эргүүлж ашиглах чадамжийн талаархи материалын тооцоог хийж, тодорхойлсон байвал зохино.

Тайлбар: Дахин боловсруулж ашиглах тогтолцооны тухай жишээ танилцуулга нь дахин боловсруулж ашиглахтай холбогдсон чадамжийг тооцон гаргахад мэдээлэл болж өгнө. ISO/TR 14049, Байгаль орчны менежмент- Амьдралын мөчлөгийн үнэлгээ-ISO 14041 тоот стандартуудад олон жишээг дурдсан болно.

1.А дугаар зураг